



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

**АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААР ДАМЖИН ОЛГОГДОЖ БУЙ
ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ
/ДОА-2018-01-НА/**



Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл нийт зээлийн 30 хувийг эзлэж байна.

Чойбалсан хот

2018 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын Нийцлийн
аудитын алба

Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584207

Аудитор
Б.Батжаргал
Б.Одхүү
Утас: 70584207

Гэрээт аудитор
З.Гансүх
Г.Хонгорзул

2018 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70584207
дугаарын утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,
1 давхар 02 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. Төслүүдийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж бүрэн санхүүжүүлсэн байна.

1.1 Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

1.2 Хөнгөлттэй зээлийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бүрэн санхүүжүүлсэн байна.

II Бүлэг. Хөнгөлттэй зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байна.

2.1 “Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах”, “Малын тэжээлийн үйлдвэр байгуулах” төслүүд хэрэгжээгүй байна.

2.2 Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл нийт зээлийн 30 хувийг эзлэж байна.

III Бүлэг. Хөнгөлттэй зээлийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.

3.1 Хэрлэн сумын Найнги ХХК-ний зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 29.260,0 мянган төгрөгийг 2017 оны авлагын үлдэгдэлд тусгаагүй байна.

3.2 Хөнгөлөлттэй зээлийн талаарх тайлан, мэдээг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН

ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

ТӨЛБӨРИЙН АКТ

АЛБАН ШААРДЛАГА

ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ДОА	Дорнод
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХАА	Хүнс, хөдөө аж ахуй
ҮХААГ	Үйлдвэр, хөдөө, аж ахуйн газар
МЭҮТ	Мал эмнэлэг үржлийн тасаг
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
МХС	Мал хамгаалах сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторт Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын хуулиар тодорхойлсон бүрэн эрх, МУЕА-ын 2018 оны А/6 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжин олгогдож буй хөнгөлттэй зээлийн эргэн төлөлтийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.
Үүнд:

- Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, санхүүжүүлсэн эсэх
- Хөнгөлттэй зээлийн эргэн төлөлт, ашиглалтад хяналт тавьж ажилласан эсэх
- Хөнгөлттэй зээлийг бүртгэл тайланд тусгаж, холбогдох байгууллагад мэдээлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраар 2013-2017 онд дамжин олгосон хөнгөлттэй зээл, зээлийн эргэн төлөлтийн мэдээ тайлан, дотоод болон хөндлөнгийн хяналтын баримт материалыг хамрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2013-2017 онуудад Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах, Мах сүүний чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах, Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах, Малын тэжээлийн үйлдвэр байгуулах, Хүлэмж, Үрслэг бойжуулагчдыг дэмжих зэрэг төслүүдэд хөнгөлттэй зээл олгосон байна. Нийт зээлийн авлага 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 128870,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа нэгтгэх, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, цуглуулсан судалгааны баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулсан.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Тариалангийн тухай хууль
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоол, “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр
- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоол, “Монгол мал” үндэсний хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоол, “Чацаргана” хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоол, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөр
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, аудитор Б.Батжаргал, Б.Одхүү, гэрээт аудитор З.Гансүх, Г.Хонгорзул нар гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 01-ий өдрөөс эхэлж 04 дүгээр сарын 20-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулсан.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг. Төслүүдийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж бүрэн санхүүжүүлсэн байна.

1.1 Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн ХХААГ-аар дамжин олгогдсон хөнгөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа нь 2013, 2014, 2015, 2017 онуудад холбогдох хууль журмуудын дагуу зохион байгуулагдсан байна. Тухайлбал:

Дорнод аймгийн Засаг даргын 2014 оны А/553 тоот захирамжаар “Малын үүлдэр угсааг сайжруулах” төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн ҮХААГ-ын даргад шилжүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн ҮХААГ-ын даргын тушаалаар “Малын үүлдэр угсааг сайжруулах” төслийн үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Үнэлгээний хорооны хурлаар харьцуулалтын аргыг сонгон, тендерийн бичиг баримтыг боловсруулахаар шийдвэрлэж, “Найнги” ХХК, “Санбэйс” ХХК, “Хүеэ Цогцолбор” гэсэн 3 аж ахуйн нэгжид үнийн санал ирүүлэх урилгыг хүргүүлсэн байна.

2015 оны 4 дүгээр сарын 03 тоот үнэлгээний хорооны хурлаар “Санбэйс” ХХК-ний ирүүлсэн Махны чиглэлийн өндөр ашиг шимт үржлийн 10 толгой эр бяруу нийлүүлэх үнийн саналыг олонхийн саналаар дэмжиж гэрээ байгуулан ажилласан байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2015 оны А/01 тоот захирамжаар өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Хүлэмж”, “Үрслэг бойжуулагчдыг дэмжих” төслүүдийг санхүүжүүлэх, төсвийг зарцуулах эрхийг аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн даргад шилжүүлж, төслийн журмыг 2 дугаар хавсралтаар баталсан байна.

ҮХААГ-ын даргын 2015 оны А/01 тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулсан байна. Үнэлгээний хорооны хурлаар “Хүлэмж”-ийн төсөл сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар шалгаруулахаар шийдвэрлэж оролцох саналыг “Мөнх ногоон тал” ХХК, ХХААЯ-ны ТЭДС болон “Түмэн верум” ХХК-уудад хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. Мөн “Үрслэг бойжуулагчдыг дэмжих” төслийн сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан байна.

Үүний дагуу “Хүлэмж”-ийн төсөлд оролцох үнийн саналаа “Түмэн верум” ХХК-аас ирүүлж гэрээ байгуулсан байна. “Үрслэг бойжуулагчдыг дэмжих” төсөлд ирүүлсэн иргэдийн саналаас шалгаруулж 8 иргэнтэй гэрээ байгуулсан байна.

1.2. Хөнгөлттэй зээлийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бүрэн санхүүжүүлсэн байна.

Аймгийн ХХААГ-ын Мал хамгаалах сангаар дамжин 2013-2017 онуудад Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах, Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах, Мах сүүний чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах, Малын тэжээлийн үйлдвэр байгуулах, Хүлэмж, Үрслэг бойжуулагчдыг дэмжих зэрэг нийт 14 төслийн 13 аж ахуй нэгж, 67 иргэнд хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Нийт олгосон зээлийн 65 хувийг мал аж ахуйн чиглэлээр, 35 хувийг газар тариалан тариалангийн чиглэлээр олгосон байна.


График 1



Мал хамгаалах сангаас олгосон зээлүүдийг он тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 2013 онд 150000,0 мянган төгрөгийн хөнгөлттэй зээл олгохоор төлөвлөснөөс, Бог малын хээлтүүлэгчийн үржлийн үйлчилгээний нэгж байгуулах төсөлд 50000,0 мянган төгрөг, Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах төсөлд 60000,0 мянган төгрөг, Мах сүүний чиглэлийн Үржлийн аж ахуй байгуулах төсөлд 39501,0 мянган төгрөг, нийт 149501,0 мянган төгрөгийн зээл олгосон байна.
- 2014 онд 70.000,0 мянган төгрөгийн хөнгөлттэй зээл олгохоор төлөвлөснөөс Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах төсөлд 25.000,0 мянган төгрөг Хадлангийн механикжсан салаа байгуулах төсөлд 25.000,0 мянган төгрөг Махны чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах төсөлд 19.332,0 мянган төгрөг нийт 69.932,0 мянган төгрөгийн зээл олгосон байна.
- 2015 онд 190.000,0 мянган төгрөгийн хөнгөлттэй зээл олгохоор төлөвлөснөөс Малын тэжээлийн үйлдвэр байгуулах төсөлд 42.000,0 мянган төгрөг, Үрслэг бойжуулагчдыг дэмжих төсөлд 12.000,0 мянган төгрөг, Малын үйлдвэр угсааг сайжруулах төсөлд 49.800,0 мянган төгрөг, Мотоблок, культватор төсөлд 38.0000,0 мянган төгрөг, Хүлэмж төсөлд 46.000,0 мянган төгрөг нийт 187.973,3 мянган төгрөгийн зээл олгосон байна.
- 2017 онд 30.000,0 мянган төгрөгийн хөнгөлттэй зээл олгохоор төлөвлөснөөс Хадлангийн техник, төхөөрөмж шинэчлэх төсөлд 30.000,0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

График 2



II Бүлэг. Хөнгөлттэй зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байна.

2.1 “Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах”, “Малын тэжээлийн үйлдвэр байгуулах” төслүүд хэрэгжээгүй байна.

Хүснэгт 1 /Төслийн зээлийн ашиглалтын байдал 2013 он/

Төслийн нэр:			"Бог малын хээлтүүлэгчийн үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"	
№	Сумын нэр	Зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэрс	Санхүүжилтийн дүн	Зориулалтын дагуу ашигласан эсэх /тийм, үгүй/
1	Чойбалсан	"Талын танан эрдэнэ" ХХК Д.Бадамцэцэг	12,500,000	тийм
Дүн			12,500,000	
Төслийн нэр:			"Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах"	
1	Хэрлэн	"Дорнод хийц" ХХК Б.Гэрэлт-Оч	60,000,000	үгүй
Дүн			60,000,000	
Төслийн нэр:			"Мах, сүүний чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах"	
1	Чойбалсан	М.Наранбаяр	13167000 /9 үхэр/	тийм
2	Чойбалсан	Ц.Баярцогт	13167000 /9 үхэр/	тийм
3	Булган	Х.Бат-Эрдэнэ	13167000 /9 үхэр/	тийм
Дүн			39,501,000	
Төслийн нэр:			"Бог малын хээлтүүлэгчийн үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"	
1	Гурванзагал	Г.Цэрэндулам	12,500,000	тийм

2	Дашбалбар	"Цогийн давст нуур" ББН Ц.Цэрэндаш	12,500,000	үгүй
3	Чойбалсан	"Талын танан эрдэнэ" ХХК Д.Бадамцэцэг	12,500,000	тийм
Дүн			37,500,000	
Нийт дүн			149,501,000	-

Хэрлэн сумын "Дорнод хийц" ХХК нь "Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах"-д ариутгасан сүүний эрэлт муу байгаа шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй, Дашбалбар сумын "Цогийн давст нуур" ББН нь "Бог малын хээлтүүлэгчийн үржлийн үйлчилгээний нэгж байгуулах" чиглэлээр 2015 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хүснэгт 2 /Төслийн зээлийн ашиглалтын байдал 2014 он/

Төслийн нэр:			"Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"	
№	Сумын нэр	Зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэрс	Санхүүжилтийн дүн	Зориулалтын дагуу ашигласан эсэх /тийм, үгүй/
1	Хэрлэн	"Дорнын цагаан дэрс" ХХК Б.Алтантогос	15,000,000	үгүй
Дүн			15,000,000	
Төслийн нэр:			"Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"	
1	Булган	"Тэнгисийн хаан" ХХК А.Төгсбаяр	10,000,000	үгүй
Дүн			10,000,000	
Төслийн нэр:			"Хадлангийн механикжсан салаа байгуулах"	
1	Хэрлэн	ШШГАЛба	25,000,000	тийм
Дүн			25,000,000	
Төслийн нэр:			"Махны чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах"	
1	Сэргэлэн	Д.Бямбадорж	4983000 /4 үхэр/	тийм
2	Сэргэлэн	Ш.Мөнхбямба	4983000 /4 үхэр/	тийм
3	Булган	Д.Алтангэрэл	4983000 /4 үхэр/	тийм
4	Булган	Р.Баатарсүх	4983000 /4 үхэр/	тийм
Дүн			19,932,000	
Нийт дүн			69,932,000	-

Хэрлэн сумын "Дорнын цагаан дэрс" ХХК, Булган сумын "Тэнгисийн хаан" ХХК-иуд нь 2014 онд "Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах" төсөл авсан боловч 2016 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хүснэгт 3 /Төслийн зээлийн ашиглалтын байдал 2015 он/

Төслийн нэр:			"Малын тэжээлийн үйлдвэр байгуулах"	
№	Сумын нэр	Зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэрс	Санхүүжилтийн дүн	Зориулалтын дагуу ашигласан эсэх /тийм, үгүй/
1	Хэрлэн	Найнги ХХК	42,000,000	үгүй
Дүн			42,000,000	
Төслийн нэр:			"Үрслэг бойжуулагчдийг дэмжих"	
1	Хэрлэн	8 иргэн	12,000,000	тийм
Дүн			12,000,000	
Төслийн нэр:			"Малын үйлдвэр угсааг сайжруулах"	
1	Баян-Уул	"Үет цагааны гол" ХХК	5000000 /1 бух/	тийм
2	Баяндун	С.Төмөрхуяг	5000000 /1 бух/	тийм
4	Дашбалбар	Ц.Чулуунбаатар	5000000 /1 бух/	тийм
5	Гурванзагал	С.Бат-Очир	5000000 /1 бух/	тийм
6	Матад	Х.Ганбаяр	4960000 /1 бух/	тийм
7	Халхгол	В.Жаргал	4960000 /1 бух/	тийм
8	Хөлөнбуйр	Ш.Шаравжамц	4960000 /1 бух/	тийм
9	Цагаан-Овоо	Ц.Баатарцогт	5000000 /1 бух/	тийм
10	Сэргэлэн	Н.Удирсад	4960000 /1 бух/	тийм
11	Чулуунхороот	Д.Энхтайван	4960000 /1 бух/	тийм
Дүн			49,800,000	
Төслийн нэр:			"Мотоблок, культиватор"	
1	Хэрлэн	20 иргэн	38,000,000	тийм
Дүн			38,000,000	
Төслийн нэр:			"Хүлэмж"	
1	Хэрлэн	10 иргэн	18,000,000	тийм
2	Баянтүмэн	5 иргэн	9,333,300	тийм
3	Цагаан-Овоо	5 иргэн	9,333,300	тийм
4	Матад	5 иргэн	9,333,400	тийм
Дүн			46,000,000	
Нийт дүн			187,800,000	

Хэрлэн сумын "Найнги" ХХК нь "Малын тэжээлийн үйлдвэр байгуулах" төслийн дагуу тоног төхөөрөмжөө бүрэн авч чадаагүй гэсэн шалтгааны улмаас үйлдвэрээ байгуулаагүй байна.

2.2 Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл нийт зээлийн 30 хувийг эзлэж байна.

Хүснэгт 4 /Төслийн зээлийн эргэн төлөлт 2013 он/

Төслийн нэр:		"Бог малын хээлтүүлэгчийн үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"						
№	Сумын нэр	Зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэрс	Санхүүжилтийн дүн	Зээл олгосон огноо	Төлж дуусах огноо	Нийт төлвөл зохих хүү, зээлийн төлбөр	Зээлийн эргэн төлөлт	Төлөгдөөгүй үлдэгдэл
1	Чойбалсан	"Талын танан эрдэнэ" ХХК Д.Бадамцэцэг	12,500,000	2013.12	2016.12	13,250,000	13,250,000	-
Дүн			12,500,000			13,250,000	13,250,000	
Төслийн нэр:		"Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах"						
1	Хэрлэн	"Дорнод хийц" ХХК Б.Гэрэлт-Оч	60,000,000	2013.10.02	2016.11.02	64,800,000	23,714,824	41,085,176
Дүн			60,000,000			64,800,000	23,714,824	41,085,176
Төслийн нэр:		Мах, сүүний чиглэлийн "Үржлийн аж ахуй байгуулах" /27 толгой үхэр/						
1	Чойбалсан	М.Наранбаяр	13,167,000	2013.09.30	2018.09.30	13,167,000	-	-
2	Чойбалсан	Ц.Баярцогт	13,167,000	2013.09.30	2018.09.30	13,167,000	-	-
3	Булган	Х.Бат-Эрдэнэ	13,167,000	2013.09.30	2018.09.30	13,167,000	-	-
Дүн			39,501,000			39,501,000		
Төслийн нэр:		"Бог малын хээлтүүлэгчийн үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"						
1	Гурванзагал	Г.Цэрэндулам	12,500,000	2013.09	2016.12	13,250,000	13,250,000	0
2	Дашбалбар	"Цогийн давст нуур" ББН Ц.Цэрэндаш	12,500,000	2013.09	2016.12	13,250,000	500,000	12,750,000
3	Чойбалсан	"Талын танан эрдэнэ" ХХК Д.Бадамцэцэг	12,500,000	2013.09	2016.12	13,250,000	13,250,000	0
Дүн			37,500,000			39,750,000	27,000,000	12,750,000
Нийт дүн			149,501,000	-	-	157,301,000	63,964,824	53,835,176

Аймгийн ХХААГ-аас авлага барагдуулах арга хэмжээ зохион байгуулж хугацаандаа зээлээ төлөөгүй иргэн, аж ахуй нэгжүүдийг 2016 онд Дорнод аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд өгч "Дорнод хийц" ХХК-ний зээлээс 23714,8 мянган төгрөг, Дашбалбар сумын "Цогийн давст нуур" ББН-ийн зээлээс 500,0 мянган төгрөгийг тус тус төлүүлсэн байна.

Аж ахуй нэгж, иргэнд 2013 онд нийт 149.501,0 мянган төгрөгийн зээл олгосноос хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 53.835,1 мянган төгрөг байна. Үүнд: "Дорнод хийц" ХХК-ний зээлийн үлдэгдэл 41.085,1 мянган төгрөг, Дашбалбар сумын "Цогийн давст нуур" ББН-ийн зээлийн үлдэгдэл 12.750,0 мянган төгрөг байна.

Хүснэгт 5 /Төслийн зээлийн эргэн төлөлт 2014 он/

Төслийн нэр:		"Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"						
№	Сумын нэр	Зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэрс	Санхүүжилт ийн дүн	Зээл олгосон огноо	Төлж дуусах огноо	Нийт төлвөл зохих хүү, зээлийн төлбөр	Зээлийн эргэн төлөлт	Төлөгдөөгүй үлдэгдэл
1	Хэрлэн	"Дорнын цагаан дэрс" ХХК Б.Алтантогос	15,000,000	2014-11-21	2017.11.21	15900000	5424385	10,475,615
Дүн			15,000,000			15900000	5424385	10,475,615
Төслийн нэр:		"Бог малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах"						
1	Булган	"Тэнгисийн хаан" ХХК А.Төгсбаяр	10,000,000	2014-12-01	2017.11.21	10500000	3,101,301	7,398,699
Дүн			10,000,000			10500000	3101301	7,398,699
Төслийн нэр:		"Хадлангийн механикжсан салаа байгуулах"						
1	Хэрлэн	ШШГАлба	25,000,000	2014.11.18	2017.10.20	27250000	27250000	0
Дүн			25,000,000			27250000	0	0
Төслийн нэр:		"Махны чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах" /16 толгой үхэр/						
1	Сэргэлэн	Д.Бямбадорж	4,983,000	2014.10.09	2019.06.30	4,983,000	-	-
2	Сэргэлэн	Ш.Мөнхбямба	4,983,000	2014.10.09	2019.06.30	4,983,000	-	-
3	Булган	Д.Алтангэрэл	4,983,000	2014.10.09	2019.06.30	4,983,000	-	-
4	Булган	Р.Баатарсүх	4,983,000	2014.10.09	2019.06.30	4,983,000	-	-
Дүн			19,932,000			19,932,000	0	0
Нийт дүн			69,932,000	-	-	73,582,000	8,525,686	17,874,314

Авлага барагдуулах ажлын хүрээнд "Дорнын цагаан дэрс" ХХК-ний зээлээс 5424,4 мянган төгрөг, "Тэнгисийн хаан" ХХК-ний зээлээс 3101,3 мянган төгрөгийг тус тус төлүүлсэн байна.

Аж ахуй нэгж, иргэнд 2014 онд нийт 69932,0 мянган төгрөгийн зээл олгосноос хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 17874,3 мянган төгрөг байна. Үүнд: Хэрлэн сумын "Дорнын цагаан дэрс" ХХК-ний зээлийн үлдэгдэл 10475,6 мянган төгрөг, Булган сумын "Тэнгисийн хаан" ХХК-ний зээлийн үлдэгдэл 7398,7 мянган төгрөг байна.

Хүснэгт 6 /Төслийн зээлийн эргэн төлөлт 2015 он/

Төслийн нэр:		"Малын тэжээлийн үйлдвэр байгуулах"						
№	Сумын нэр	Зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэрс	Санхүүжилтийн дүн	Зээл олгосон огноо	Төлж дуусах огноо	Нийт төлвөл зохих хүү, зээлийн төлбөр	Зээлийн эргэн төлөлт	Төлөгдөөгүй үлдэгдэл
1	Хэрлэн	Найнги ХХК	42,000,000	2015.12.24	2018.10.23	44,520,000	15,260,000	29,260,000
Дүн			42,000,000			44,520,000	15,260,000	29,260,000
Төслийн нэр:		"Үрслэг бойжуулагчдийг дэмжих"						
1	Хэрлэн	8 иргэн	12,000,000	2015.04.16	2016.10.20	12,900,000	12,900,000	
Дүн			12,000,000			12,900,000	12,900,000	
Төслийн нэр:		"Малын үйлдвэр угсааг сайжруулах" /10 толгой бүх/						
1	Баян-Уул	"Үет цагааны гол" ХХК	5,000,000	2015.06.28	2018.06.30	5,000,000	-	-
2	Баяндун	С.Төмөрхуяг	5,000,000	2015.06.28	2018.06.30	5,000,000	-	-
4	Дашбалбар	Ц.Чулуунбаатар	5,000,000	2015.06.28	2018.06.30	5,000,000	-	-
5	Гурванзагал	С.Бат-Очир	5,000,000	2015.06.28	2018.06.30	5,000,000	-	-
6	Матад	Х.Ганбаяр	4,960,000	2015.06.28	2018.06.30	4,960,000	-	-
7	Халхгол	В.Жаргал	4,960,000	2015.06.28	2018.06.30	4,960,000	-	-
8	Хөлөнбуйр	Ш.Шаравжамц	4,960,000	2015.06.28	2018.06.30	4,960,000	-	-
9	Цагаан-Овоо	Ц.Баатарцогт	5,000,000	2015.06.28	2018.06.30	5,000,000	-	-
10	Сэргэлэн	Н.Удирсад	4,960,000	2015.06.28	2018.06.30	4,960,000	-	-
11	Чулуунхороот	Д.Энхтайван	4,960,000	2015.06.28	2018.06.30	4,960,000	-	-
Дүн			49,800,000			49,800,000	0	0
Төслийн нэр:		"Мотоблок, культиватор"						
1	Хэрлэн	20 иргэн	38000000	2015.03.30	2016.10.20	38,000,000	28,411,433	9,588,567
Дүн			38,000,000			38,000,000	28,411,433	9,588,567
Төслийн нэр:		"Хүлэмж"						
1	Хэрлэн	10 иргэн	18,000,000	2015.05.11	2016.10.20	18,756,000	13,813,600	4,942,400
2	Баянтүмэн	5 иргэн	9,333,300	2015.05.11	2016.10.20	9,725,335	4,127,599	5,597,736
3	Цагаан-Овоо	5 иргэн	9,333,300	2015.05.05	2016.10.20	9,725,335	7,025,201	2,700,134
4	Матад	5 иргэн	9,333,400	2015.05.18	2016.10.20	9,725,335	4,201,067	5,524,268
Дүн			46,000,000			47932005	29167467	18,764,538
Нийт дүн			187,800,000	-	-	193,152,005	85,738,900	57,613,105

Аж ахуй нэгж, иргэнд 2015 онд нийт 187800,0 мянган төгрөгийн зээл олгосноос хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 57613.1 мянган төгрөг байна. Үүнд: "Найнги" ХХК-ний зээлийн үлдэгдэл 29260,0 мянган төгрөг, "Мотоблок, культиватор" төслийн зээлийн үлдэгдэл 9588.5 мянган төгрөг, "Хүлэмж" төслийн зээлийн үлдэгдэл 18764.5 мянган төгрөг байна.

Аймгийн ХХААГ-аас төслийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийг барагдуулах зорилгоор Хүлэмж авсан сумдын ЗДТГ-т хугацаандаа төлөгдөөгүй зээлийг төлүүлэх талаар албан бичиг хүргүүлсэн байна.

III Бүлэг. Хөнгөлттэй зээлийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.

3.1 Мал хамгаалах сангаас 2015 онд олгосон зээлийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.

Мал хамгаалах сангаас 2013-2017 онуудад нийт 12 төсөл сонгон шалгаруулж 13 аж ахуйн нэгж, 67 иргэнд 437233,0 мянган төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон байна.

Хөнгөлттэй зээлүүдийг Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд тусган Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн байна.

Мал хамгаалах сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагийн үлдэгдэл 128870,8 мянган төгрөг байна.

Хэрлэн сумын “Найнги” ХХК-д 2015 онд “Малын тэжээлийн үйлдвэр байгуулах” төслийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 29260,0 мянган төгрөгийн авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй байна.

Иргэн, аж ахуй нэгжид 2013 онд олгосон “Мах, сүүний чиглэлийн үржлийн мал аж ахуй төсөл”-ийн 39501,0 мянган төгрөгийн 27 үхэр, 2014 онд олгосон “Махны чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах төсөл”-ийн 19932,0 мянган төгрөгийн 16 үхрийг хөрөнгө эзэнгүйдэхээс сэргийлж ХХААГ-ын малын дансанд бүртгэж, 2015 онд олгосон “Малын үйлдвэр угсааг сайжруулах” төслийн 49800,0 мянган төгрөгийн 11 бухыг сумдад шилжүүлж, сумдын ЗДТГ-ын санхүүгийн тайланд тусгасан байна.

3.2 Хөнгөлөлттэй зээлийн талаарх тайлан, мэдээг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

ХХААЯ-ны ТЭДС-аас төмс, хүнсний ногооны 20 иж бүрдэл бага оврын тоног төхөөрөмжийг 5 сумын өрхийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд 30% урьдчилгаа төлбөртэйгээр олгож. Тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгааны сургалтыг ХХААЯ-ны ТЭДС, Баянтүмэн сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан байна. Тус сургалтанд 9 сумын МЭҮТ-ийн Газар тариалан хариуцсан мэргэжилтэн, 3 сумын тариаланчдын төлөөлөл нийт 45 хүн оролцсон байна.

Аймгийн ХАА газраас 2015 онд 6х18 хэмжээтэй 108 м² бүхий 46000,0 мянган төгрөгийн өртөгтэй 25 ширхэг хүлэмжийг Хэрлэн, Баянтүмэн, Цагаан-Овоо, Матад сумдын өрхийн тариалан эрхлэгчдэд 30% урьдчилгаа төлбөртэйгээр зээлээр олгосны үр дүнд 2500 м² талбай бүхий хүлэмжийн тариалалт нэмэгдэж 10,5 тн ургац хураан авсан дүн мэдээ гарсан байна.

Мөн хүлэмж нийлүүлэгч Түмэн Верум ХХК хүлэмжийн аж ахуйн сургалтыг аймгийн төв Чойбалсан хотод зохион байгуулж сургалтанд 7 сумын 60 өрхийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид оролцож хүлэмжийн тариалалтын арга технологи болон хүлэмж угсрах заавар зөвлөмжийн мэдээллийг өгсөн байна.

Хөнгөлөлттэй зээлийн мэдээ тайлан, түүний үр дүнг аймгийн ХАА газрын жилийн эцсийн тайланд тусган ХХААЯ-нд хүргүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төслүүдийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж бүрэн санхүүжүүлсэн байна.
2. Хөнгөлөлттэй зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байна.
3. Хөнгөлөлттэй зээлийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ХХАА газрын дарга Б.Батсайхан, Нягтлан бодогч Б.Золзаяа нарт зөвлөж байна.

Үүнд:

1. Хөнгөлттэй зээлийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.
2. Төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулах ажлыг зохион байгуулах.
3. Хэрлэн сумын “Найнги” ХХК-ний зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 29.260,0 мянган төгрөгийг авлагын үлдэгдэлд тусгах.

Аудитаар нийт 158582.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 29260,0 мянган төгрөгийн албан шаардлага, 129322,6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2018 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР